

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн
2022 оны 12 сарын 15 өдрийн 31160
дугаар албан бичгийн 4 дүгээр хэвсрэлт
ЭМНЭЛЭГ

УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛТЫН
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН
(2022 он)

2022.12.15

№	ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХҮРЭХ ҮР ДҮН	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭРЭГЖИХ ХУГАЦАА				ТАЙЛАН
				2	2	2	2	
				0	0	0	0	
				2	2	2	2	
				0	1	2	3	
Зорилт 1. Эрүүл мэндийн ажилтны аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийг нь хамгаалах								
1.1	Эрүүл мэндийн байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг тогтмол хугацаанд холбогдох талуудтай хамтран үнэлэх, шаардлагатай дүрэм, журмыг шинээр болон шинэчлэн боловсруулахад санал өгөх	Шинэчлэгдсэн дүрэм, журам	Өгсөн санал					- Ерөнхий захирлын 2022 оны А/59 дүгээр тушаалаар эмнэлгийн "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зөвлөл"-ийн бүрэлдэхүүн болон дүрмийг шинэчлэн баталсан. - Ерөнхий захирлын 2022 оны А/141 дүгээр тушаалаар эмнэлгийн "Лифтний аюулгүй ажиллагааг ханган ажиллах тухай" журмыг шинэчлэн баталсан. - Ерөнхий захирлын 2022 оны А/143 дугаар тушаалаар эмнэлгийн "Гал түймэр, галын аюулаас урьдчилан сэргийлэх ажиллагааны тухай" журмыг шинэчлэн баталсан. - Ерөнхий захирлын 2022 оны А/144 дугаар тушаалаар эмнэлгийн "Цахилгаан хангамж, аюулгүй ажиллагааны тухай" журмыг шинэчлэн баталсан.
1.2	Мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх	Мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, ослыг тэглэх үйл ажиллагааны төлөвлөгөө	Батлагдсан төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан Дозиметрт хэмжилт хийлгэсэн ажилтны тоо					Эрүүл мэндийн ажилтныг эмнэлэгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх зорилгоор "Өртөлт, өртөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээ" сэдэвт 1 сарын аян зохион байгуулсан. Аяны эмнэлгийн хэмжээнд өртөлт хариуцсан 50 ажилтан бэлтгэгдсэн. ӨДС-ийн цомгийн жагсаалт, хөтлөх маягт хуудас, зааврыг эмнэлгийн хэмжээнд ижил болгож тасгуудад хүргүүлсэн. В гепатитын дархлаа тогтоц үзэх шинжилгээнд 400 эрүүл мэндийн ажилтанг хамруулж В гепатитын вакцин 2 тунд 133, 3 тунд 25 эрүүл мэндийн ажилтан

							хамрагдсан. Өртөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээ сэдвээр 2 удаагийн давтамжтай 50 эрүүл мэндийн ажилтанд танхмийн сургалт зохион байгуулсан. Мэдлэг үнэлэх 10 асуумж бэлтгэн эрүүл мэндийн ажилтанг сургалтын өмнө болон дараа тестийн үнэлгээнд хамруулсан. Өртөлт сэдвээр сургалтын өмнө 22 эрүүл мэндийн ажилтны мэдлэгийг үнэлэхэд дундаж үнэлгээ 52.1% байв. Эмнэлгийн хэмжээнд нийт 41 ажилтан мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтанд хамрагддаг бөгөөд сар бүрийн 27-нд МХЕГ-ийн цацрагийн хяналтын лабораторид хэмжилтэнд явуулж байна.
1.3	Эмнэлгийн ажилтнуудын ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар үе шаттай хийлгэх	Эмнэлгийн ажилтнуудын ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг эрх бүхий байгууллагын хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ	Эмнэлгийн ажилтнуудын ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэх				Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын газрын Туршилт хэмжилтийн төв эмнэлгийн дараах 5 төв, тасаг, хэсгийн мэргэжилтнүүдийн ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгүүлэх хүсэлтийг хүргүүлсэн. - Дурангийн төвд ажилладаг эмч, сувилагч - Зүрхний ангиографийн хэсгийн эмч, сувилагч - Зүрхний шигдээсийн хэсгийн эмч, сувилагч, туслах сувилагч - Харвалтын хэсгийн эмч, сувилагч, туслах сувилагч - Гемодиализын хэсгийн эмч, сувилагч
1.4	Эрүүл мэндийн ажилтнуудтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг холбогдох талуудтай хамтран тогтмол хугацаанд байгуулах, шаардлагатай тохиолдолд шинэчлэх, хөдөлмөрийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	Шинээр ажилд орсон эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан Шаардлагатай тохиолдолд шинэчлэн байгуулсан гэрээ	Шинээр ажилд орсон эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны тоо Шаардлагатай тохиолдолд шинэчлэн байгуулсан гэрээний тоо				- Шинээр ажилд орсон нийт 119 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан. - Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д нийцүүлэн "Эмнэлгийн хөдөлмөрийн дотоод журам"-ыг шинэчлэн боловсруулан Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар батлан, хэрэгжүүлж эхэлсэн. Шинэчлэн баталсан Хөдөлмөрийн дотоод журмын дагуу эмнэлгийн удирдах ажилтан, хэсэг, тасаг, албадын нийт 43 албан тушаалтантай "Хөдөлмөрийн гэрээ" шинээр болон шинэчлэн байгуулсан

1.5	“Тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр townsгоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад салбарын ажил, мэргэжлийн жагсаалт, шинээр нэвтэрч буй техник, технологитой уялдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээр холбогдох байгууллагад санал өгөх	Холбогдох газраас батлагдсан дүрэм, журам	Өгсөн санал					Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын газрын Туршилт хэмжилтийн төв эмнэлгийн дараах 5 төв, тасаг, хэсгийн мэргэжилтнүүдийн ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгүүлэх хүсэлтийг хүргүүлсэн. 1. Дурангийн төвд ажилладаг эмч, сувилагч 2. Зүрхний ангиографийн хэсгийн эмч, сувилагч 3. Зүрхний шигдээсийн хэсгийн эмч, сувилагч, туслах сувилагч 4. Харвалтын хэсгийн эмч, сувилагч, туслах сувилагч 5. Гемодиализын хэсгийн эмч, сувилагч
1.6	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, <i>аюулгүй хөдөлмөрийн эрүүл ахуйн</i> чиглэлийн сургалт, сурталчилгааг эмнэлгийн удирдах ажилтнууд болон эрүүл мэндийн мэндийн ажилтнуудад тогтмол	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, аюулгүй хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлийн сургалт	Сургалтын төлөвлөгөө, тайлан Зохион байгуулагдсан сургалтын тоо					- Байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль дүрэм боловсруулж, байгууллагын дотоод журам батуулан тасаг нэгжүүд, ажлын байрны заавар зөвлөгөө өгч, зарим тасагт нэгжүүдэд шинээр дүрэм боловсруулж ажиллаж байна. 18 тасаг хэсгийн давхардсан тоогоор 355 ажилтанд хөдөлмөр аюулгүй байдлын зааварчилгааг ажлын байр бүрийн онцлогт уялдуулан өгсөн. 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр “Галын болон эрсдэл,аюулгүй байдлын сургалт”-ыг Гал Импекс ХХК-ний Сургагч багш А.Батмөнх галын аюулаас сэргийлэх, аюулгүй байдлыг хангах, гал унтаарах мэдлэгтэй байх, галын эх үүсвэрээс сэргийлэх, галын хорны уршиг түүнийг арилгах, бэлэн байдлын талаар сургалтыг эмнэлгийн 142 ажилтанг хамруулан зохион байгуулав 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр “Хөдөлмөрийн эрүүл ахуйн тухай” сургалтыг эмнэлгийн нийт 42 удирдах ажилтан, дунд шатны менежер нарт Хөдөлмөрийн хамгаалал, хүний хөгжлийн төв ТББ-ын тэргүүн С.Дуламсүрэн, хуулийн зөвлөх Болорчимэг нар зохион байгуулсан. - ХАА-ны сургалтыг гадны мэргэжилийн байгууллагаас галын сургалт болон ХАА-ны мэдээ мэдээл, ХАА-ны сарын аяны хүрээнд 4 тасагт сургалт хийгдэв.Самсунг Бомитой хамран

								инженерүүд сургалт, КОФИН төслийн хүрээнд сургалт хийгдсэн. - Тасгуудын ХААЭА-н үйл ажиллагааг хэвшүүлэх өдөр тутмын хөтлөж сургаж, сургалт заавар зааварчилгаа тасгуудад хийгдэж байна.  - ХАБЭА-н зүгээс Эрсдэлийн аудит тойрон үзлэг хийхдээ барилга байшингийн гадна, дотно унах бэртэх эрсдэл, барилгын гадна орчины аюулгүй байдал, тэмдэг тэмдэглэгээ харах, Алба тасаг нэгжүүдэд цахилгааны аюулгүй байдал, галаас сэргийлэх багаж төхөөрөмж, сангийн бүрэн бүтэн аюул байдал, эмнэлэгийн тоног төхөөрөмж түүний ашиглаж буй аюулгүй ажиллагаа, ажлын байрны эрүүл ахуй, ажлын хувцас, халдваргүйчлэл, байгууламж дотор гадна эмх цэгц үзэмж, мэдээлэлийн самбар хаягжилалтыг шалгаж шаардлага тавьж зөвлөмж үүрэг өгч ажиллаж байна. - Барилга байгууламж, Тусгай Тасагт, ХШТБ Тасагт галын хөнжил байршуулж, Хүүхдийн цэцэрлэгт галын хор, галын хөнжил байршуулж, Дүрс Оношлогооны тасаг, Эм хангамжын Алба, Авто гараж тасаг, Хангамж үйлчилгээний Алба, ИБА, Радиологийн тасаг, Оношлогооны тасагуудад Галын үзлэг аюулгүй ажиллагаа тэмдэг тэмдэглэгээ, хяналт хийж, галын хор ажиллуулах сургалт зөвлөгөөг өгч, галын мэдээлэлийн самбар тавьж тойрон үзлэг хийгдэв. - Барилга байгууламжын орчины эрүүл ахуйн аюулгүй байдал нь галын хор 162, галын хайрцаг 54, галын гарц 27, агааржуулалтын решотка 240, ослын гарцын гэрэлтэй тэмдэглэгээ 254 байна - ХАБ-ын зүгээс галын хорыг ажиллуулах ашиглах заавар зааварчилгаа өгч, шалгалт авсан Уламжлалын тасгийн ахлах
--	--	--	--	--	--	--	--	--



Төв байр болон 50 ортын Лифтэнд засвар үйлчилгээ хийхэд аюулгүй байдлыг шалгаж, Лифтэнд тойрон үзлэг хийж, хонгилд дахь хог хаягдлыг цэвэрлүүлэв. Мөн техникийн ажиллагааг хянаж, удирдлага хяналт, хаалганы мэдрэгч солиулсан

Лифтний хонгил, бүхээгний зам, торос, үйлчилгээ хийгдэхэд хяналт тавьж, зөвлөмж зөвөлгөө өгөгдөв.



Шалгалтын явцад Байгууллагын гадна орчин гэрэлтүүлэггүй , замын тэмдэглэгээг сайжруулах, гарцын тэмдэглэгээ таних тэмдэг байхгүй, зүг чиг заасаг хаяг тэмдэглэгээ байхгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд тохирсон замын тэмдэглэгээ,

							барилга байгууламжын гадна дотор хана, хананы фасат унасан, цууралттай, сүлжээ болон цахилгаан утас татсан унжсан, кислород болон баллон хүлээн авах, ачиж буулгахад зогсоол байхгүй эрсдэл ихтэй, тамхины цэг байгуулах шаардлагатай /цэг байхгүй/ хог хаягдал ихтэй, байгууламжын дотор өрөөнүүдэд галын болон цахилгаан аюулгүй байдлын мэдээлэх самбар хаяг хийгдэх, тоног төхөөрөмжийн кабель утаснууд эмх замбааргүй, интернетийн сүлжээний утаснууд далдлагч болон холбосон кабелууд ил эрсдэл доголдол гарах өндөр учир аюулгүй байдлыг хангах шаардлага хүргүүлж шийдвэрлэсэн.
1.7	Эрүүл мэндийн ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан нэгдсэн загвар бүхий ажлын хувцас, ажлын хэрэгслээр бүрэн хангаж, жил бүр шинэчлэх	Ажилтнуудад олгосон нэгдсэн загвар бүхий ажлын хувцас	Зарцуулсан хөрөнгө				02022 онд Их уул трейд ХХК-тай №НХ3Э/22/02 тоот нормын хувцас худалдах худалдан авах гэрээг 50,736,000 төгрөгөөр, "Оюу гандирс ХХК"-тай №НХ3Э/22/03 тоот цагаан хэрэглэл, даавуу, хулдаас, худалдах худалдан авах гэрээг 114,890,000 хийгдсэн. 2022 оны нормын хувцас тоо 20ш 50,736,000 төгрөгний гэрээг хийсэн. - Нэг удаагийн хамгаалах хувцас, хэрэгсэл тасаг нэгжүүдэд хүрэлцээтэй 2022 онд N95 маск 4504ш 6510720 төгрөг, малгай 26996ш 5399200 төгрөг, комбинзон 11920ш 37360000 төгрөг, улавч 17700ш 4238000, бээлий 724900 ш 448132000 төгрөгийн нөөцийг татан авсан.
1.8	Шөнийн ээлжид гарсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанг заавал биеэр амруулах	Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль	Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажилласан цагийн тооцоо				- Ерөнхий захирлын 2022 оны А/124 дугаар тушаалаар эмнэлгийн "Шөнийн ээлжинд ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтны цай, хоолоор хангах" тухай тушаалыг шинэчлэн баталсан. Тушаалаар шөнийн ээлжинд ажиллах 53 эмч, сувилагч, лаборант, дэмжих үйлчилгээний тасгийн ажилтнуудад өглөөний цай, оройн хоолоор үнэ төлбөргүй хангах, долоо хоногийн амралтын өдөр болон нийтээр амрах баярын өдрүүдэд ажиллах эмнэлгийн өдрийн ээлжийн хоолны үнийг 2000 төгрөгөөр, төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж байгаа эмнэлгийн мэргэжилтнүүдэд худалдаалах үнийг 3600 төгрөгөөр тооцон олгож байна. - Эмнэлгийн ерөнхий захирлын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/85 дугаар тушаалаар нийт эмнэлгийн ажилчдад

								2,500 төгрөгийн үнэтэй 15 ширхэг иж бүрдэл хоолны жор, орц, цэсийг шинээр батлуулан өдөр бүр иж бүрдэл хоолоор үйлчилж эхэлсэн. Тус иж бүрдэл хоол нь 730-920 ккал-ийн илчлэгтэй бөгөөд энэ нь Эрүүл мэндийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/74 тоот тушаалаар батлагдсан “Хоногийн хоол хүнсээр авбал зохих ичлэг, үндсэн шимт бодисын зөвлөмж, хэмжээ, шаардлага”-ыг хангаж байгаа юм. • Эрүүл мэндийн ажилтнуудын дархлааг дэмжих зорилгоор халуун аарцаар 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс үйлчилж байна. • Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72,1 дэх заалт, Эмнэлгийн ерөнхий захирлын 2020 оны А/59 дугаар тушаалын дагуу Шөнийн цагт ажилласны нэмэгдэл 138,924 цагийн 138,924,000 төгрөг олгогдсон. • Шөнийн ээлжинд гарсан эмнэлгийн мэргэжилтэн болон ажилтныг заавал биеэр эдлэх зохицуулалтын явцыг эмнэлгийн захиргаа, удирдлагын зүгээс хяналттай ажилладаг (8/16) • Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн дагуу илүү цагаар болон 7 хоногийн амралт, нийтээр амрах баяр ёслолын өдөр ажиллуулсны хөлс болох 1,581,542,311 төгрөгийг давхардсан тоогоор нийт 2,970 эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон. • Дуудагдан ажилласны хөлс болох 80,130,160 төгрөгийг давхардсан тоогоор нийт 1,796 эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон.
1.9	Эрүүл мэндийн ажилтанг албан үүргээ гүйцэтгэж байх үедээ заналхийлэл, хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хууль эрх зүйн туслалцаа авахад дэмжлэг үзүүлэх	Хууль эрх зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлсэн байх	Хуулийн зөвлөхийг гэрээгээр ажиллуулсан тухай эмнэлгийн ерөнхий захирлын тушаал					• 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс 1 жилийн хугацаатай Монголын хуульчдын холбооны гишүүн, хуульч Ш.Нарантуяатай “Хөлсөөр ажиллах гэрээ” байгуулан ажилласан. Сар, улирал бүрийн ажлын тайланг хүлээлгэн өгсөн. • Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу "Хөдөлмөрийн дотоод журам" шинэчлэх, бэлтгэл ажлын хангах зорилгоор Эмнэлгийн үйлдвэрчний

			Гэрээгээр ажилласан хуулийн зөвлөхийн ажлын тайлан					эвлэлийн хороотой хамтран Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны А/06, А/29 тушаалаар "Ажлын хэсэг"-ийн гишүүнээр хуулийн зөвлөх Ш.Нарантуяа ажилласан. - Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, байгууллагын ил тод байдлыг хангах, байгууллагын нууцыг тогтоох, хамгаалах зорилгоор эмнэлгийн Ерөнхий захирлын 2022 оны 04 дүгээр сарын А/42 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулсан. 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрөөс 5 дугаар сарын 03-ны өдрийн хооронд ахлах сувилагч-11, дэмжих тасгийн ажилтнууд-105, сувилагч-111, резидент эмч-87, эмч-52, алба, төв, тасаг, хэсгийн эрхлэгч-39 нийт 405 эмнэлгийн ажилтнуудад эмнэлгийн Хуулийн зөвлөх, хууль зүйн ухааны магистр, хуульч Ш.Нарантуяа, Захиргаа, хүний нөөцийн албаны дарга Н.Баярмаа нар сургалт, мэдээлэл хийсэн. - Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны өдрийн А/97 дугаар тушаалаар Байгууллагын нууцыг хамгаалах журам, байгууллагын нууцад хамаарах мэдээллийн жагсаалт, нууцын баталгааны хуудасны загварыг хуулийн зөвлөхтэй хамтран боловсруулан батлуулсан
1.1 0	Жил бүр эрүүл мэндийн ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, хяналтад авсан байх	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан эрүүл мэндийн ажилтан	Эмнэлгийн ерөнхий захирлын тушаал Эрүүл мэндийн ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан тайлан					“Эмнэлгийн эрүүл мэндийн ажилтны 2022 оны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах тухай” ерөнхий захирлын 2022 оны 03 сарын 04-ны А/28 тоот тушаал гаргасны дагуу үзлэг зохион байгуулагдсан. Урьдчилан сэргийлэх үзлэгийг 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулан ажиллаа. Үзлэгт хамрагдвал зохих 524 ажилтанаас 498 хүн лабораторийн болон багажийн шинжилгээ, 439 хүн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамрагдсан байна. Мөн энэ онд давхардсан тоогоор 162 ажилтан эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн байна. Эдгээрээс 65 ажилтанд яаралтай болон төлөвлөгөөт байдлаар мэс заслын асуудал шийдвэрлэжээ. - Ажилчид 2022 онд мэс заслын тасагт хамгийн их хэвтсэн бол хоол боловсруулах эрхтэн судлалын тасаг, ковид, бөөр, дотоод шүүрлийн тасгуудад хэвтэлт бусад тасгуудаас илүү байгаа нь энэ төрлийн өвчин эмгэг давамгайлж байгааг харуулж байна.

1.1 1	Эрүүл мэндийн ажилтанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх журмыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх	Эрүүл мэндийн яамнаас батлагдсан журам	Эрүүл мэндийн яамнаас батлагдсан журмын дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлсэн байдал					- Эмнэлгийн Ерөнхий захирлын 2022 оны А/51 дүгээр тушаалаар Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн баталсан. Уг журамд эмнэлгийн эрүүл мэндийн ажилтан, тэдний гэр бүл, 18 нас хүртэлх хүүхдийг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хамруулах заалт тусгасан. - Эмнэлгийн ерөнхий захирлын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/85 дугаар тушаалаар нийт эмнэлгийн ажилчдад 2,500 төгрөгийн үнэтэй 15 ширхэг иж бүрдэл хоолны жор, орц, цэсийг шинээр батлуулан өдөр бүр иж бүрдэл хоолоор үйлчилж эхэлсэн. Тус иж бүрдэл хоол нь 730-920 ккал-ийн илчлэгтэй бөгөөд энэ нь Эрүүл мэндийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/74 тоот тушаалаар батлагдсан “Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодисын зөвлөмж, хэмжээ, шаардлага”-ыг хангаж байгаа юм.
1.1 2	Элэгний С вирусийн халдвар илэрсэн эрүүл мэндийн ажилтнуудыг вирусийн эсрэг эмчилгээнд үргэлжлүүлэн үнэ төлбөргүй хамруулах	Элэгний С вирусийн эмчилгээнд үнэ төлбөргүй хамрагдсан эрүүл мэндийн ажилтан	Элэгний С вирусийн эмчилгээнд үнэ төлбөргүй хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо					Нийт 545/36 (6.6%) нь В,С вирус тээгч байна. 24 (4.6%) нь В вирус тээгч, 16 (3%) нь С вирус тээгч байна. ВД вирусын хавсарсан халдвартай 1 эрүүл мэндийн ажилтан байна.
1.1 3	Эмнэлэгт шинээр элссэн резидент эмч нарын элэгний В вирусийн дархлаа тогтоцын түвшинг тодорхойлж, шаардлагатай резидентийг элэгний В вирусийн эсрэг сэргээх дархлаажуулалтад үнэ төлбөргүй хамруулах	Дархлаажуулалтад хамрагдсан резидент эмч	Дархлаажуулалтад хамрагдсан резидент эмчийн тоо					Эмнэлэгт шинээр элссэн нийт 175 резидент эмч нарын гепатит В вирусийн эсрэг дархлаажуулалтанд 23 резидент эмч хамрагдсан бөгөөд 1 тунд 6 (3.4%), 2 тунд 4 (2.28%) , 3 тунд 10 (5.7%) тус тус хамрагдсан байна.
1.1 4	Эрүүл мэндийн байгууллага ажилтнуудаа ажлын байранд сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж, үйлчилгээ авах боломжоор хангах	Сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж, үйлчилгээ авсан байдал	Сэтгэл зүйчийг гэрээгээр ажиллуулсан тухай эмнэлгийн ерөнхий захирлын тушаал					2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр тус эмнэлгийн хүсэлтээр “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр Монгол улсын их сургуулийн багш Г.Мягмар, “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тайлбар, мэдэгдэл гаргах, мэдэгдэл, тайлбар гаргахад анхаарах асуудлууд” сэдвээр Авилгатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар У.Номин-Эрдэнэ нар байгууллагын удирдлага, дунд шатны менежерүүд болох нийт

			Гэрээгээр ажилласан сэтгэл зүйчийн ажлын тайлан					54 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудад сургалт зохион байгууллаа. • “Эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага, ёс зүйн хэм хэмжээ” багц цагийн сургалтанд эмнэлгийн эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнг хамруулсан. • Содура консалтинг ХХК зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллагатай хамтран нийт эмнэлгийн ажилтнуудад 4 удаа ёс зүй, харилцаа, хандлага, манлайлал гэсэн сэдвүүдээр сургалт явуулсан. • Улсын хоёрдугаар төв эмнэлэг болон Содура консалтинг ХХК-ийн хамтран зохион байгуулсан ёс зүй, харилцаа хандлагын “Сургагч багшийн сургалт”-д эмнэлгийн СГХА-ны Д.Цэнджав, ЕМЗТ-ийн эмч М.Түвшинбаяр, МСТ-ийн Д.Мөнхжаргал, ЗССТ-ийн эмч Т.Байгалмаа, ЭЗХА-ны дарга О.Баяржаргал, БДШТ-ийн Э.Нарныгэрэл, СА-ны арга зүйч М.Оюунсайхан, Б.Оюунтуяа, ЗХНА-ны менежер Х.Болор, ЭМТҮЧАБА-ны менежер Б.Дулмаа, МЭЭТ-ийн сувилагч Б.Амарзаяа, РТ-ийн эмч Д.Энхжаргал нарын 12 эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан. • “Стресс менежмент ба харилцаа” сэдвээр АУ-ны доктор, сэтгэл заслын эмч, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэд захирал Н.Алтанзул 04-р сарын 12-нд нийт 120 гаруй эмч, сувилагч, ажилтанг хамруулсан сургалт зохион байгуулсан • УХТЭ-ийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо “Эмнэлгийн мэргэжилтний харилцаа, хандлага, ёс зүйн хэм хэмжээ” сэдвээр 2 удаа багц цагийн сургалтыг зохион байгуулж, нийт 360 эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэнг хамруулсан.
Зорилт 2. Эрүүл мэндийн ажилтныг ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг сайжруулах								
2.1	Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн Дотрын анагаах судлал, Дүрс оношилгоо судлал, Мэс засал судлал, Мэдрэл судлал чиглэлээр эмч бэлтгэх сургалт зохион байгуулах	Мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтнүүд	Шинээр элсэн орсон болон суралцаж байгаа суралцагчдын тоо Эрүүл мэндийн сайдын тушаал					2021-2022 оны хичээлийн жилд Дотрын анагаах судлал, Дүрс оношилгоо судлал, Мэс засал судлал, Мэдрэл судлал, Эрчимт эмчмлгээ судлал нийт 5 чиглэлийн үндсэн мэргэшлийн сургалтад 120 резидент эмч суралцаж, 34 эмч амжилттай төгсөж, 86 резидент эмч анги дэвшин суралцсан. 2022-2023 оны хичээлийн жилд 43 эмч ЭМС-ын 2022 оны А\489 дүгээр тушаалаар элсэн суралснаар нийт 127 резидент эмч Дотрын анагаах судлал, Дүрс оношилгоо судлал, Мэс засал судлал, Мэдрэл судлал, Эрчимт эмчмлгээ судлал, Яаралтай

							тусламж судлал нийт 6 чиглэлийн үндсэн мэргэшлийн сургалтад сургалтад суралцаж байна.
2.2	Төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн Мэдээгүйжүүлгийн сувилахуй, Мэс заслын сувилахуй, Эрчимт эмчилгээний сувилахуйн чиглэлээр сувилагч бэлтгэх сургалтын эрх авах	Мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтнүүд	ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн хурлын тогтоол				• “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдал” S\с /0918-01-07 төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр сургалтын эрх авсан. • “Яаралтай тусламж судлал” үндсэн мэргэшлийн сургалтад сургалтын эрх авсан • “Дурангийн онош зүй”, “Хэвлийн хөндийн хэт авиа оношилгоо” мэргэжил дээшлүүлэх сургалтад сургалтын эрх авсан байна.
2.3	Зайн сургалтын хэрэгцээнд үндэслэн аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвд зайн сургалт явуулах боломжийг бүрдүүлж, сургалтыг төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах, оролцогчдын тоог нэмэгдүүлэх	Зохион байгуулсан сургалт	Зохион байгуулсан сургалтын тоо Хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо				Үндэсний оношилгоо эмчилгээний төв болон өргөжиж, лавлагаа тусламж, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж байгаа тул бусад төрөлжсөн эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, ӨЭМТ, СЭМТ-ийн эмч нарт зориулсан 10 удаагийн багц цагийн сургалтыг танхим, цахим хосолсон хэлбэрээр 2022 онд зохион байгуулсан. Үүнд: 1. СЗЭТ-аас “Өвдөгний үений остеоартритын сэргээн засах эмчилгээний орчин үеийн чиг хандлага”, “Мөрний эмгэгийн үеийн менежмент” – 2 удаа 2. БДШТ-аас “Жирэмсэн эмэгтэйчүүдийн бөөрний өвчлөл”, “Тогтолцооны яришил өвчний орчин үеийн чиг хандлага”, “Бөөрний эмгэгтэй өвчтөнийг үнэлж сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэх нь”- 3 удаа 3. ЗССТ-аас “Зүрхний архаг өвчний оношилгоо, эмчилгээ” 4. ММЗТ-аас БНСУ-ын Гёнки аймгийн Вельсийн нэрэмжит эмнэлэгтэй хамтран “Бүсэлхий нурууны өвдөлтийн оношилгоо, эмчилгээний орчин үеийн чиг хандлага” 5. Эм зүйн албанаас “Нянгийн эсрэг эмийн эмчилгээний өнөөгийн байдал эрсдэлт бүлгийн эмчлүүлэгчдэд хэрэглэх онцлог олон эмэнд тэсвэртэй нянгийн тэсвэржилт” 6. БДШТ-аас АНУ-ын Johns Hopkins University-ийн эмч Prof. Atta Mohamed.Ph.D-тай хамтран “Бөөрний түүдгэнцэрийн өвчний оношилгоо, эмчилгээний шинэ удирдамж”, “Гемодиализ

							эмчилгээний зарим хүндрэлийн оношилгоо, эмчилгээний орчин үеийн чиг хандлага” 7. “Эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага, ёс зүйн хэм хэмжээ”- зөвхөн УХТЭ-ийн эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнг хамруулсан. Сургалт бүрийн мэдээлэлийг УХТЭ-ийн пэйж хуудаст https://www.facebook.com/ssch.gov.mn нийтэлсэн. • Санамж бичиг байгуулсан зүүн бүсийн 5 аймаг, алслагдсан 3 дүүргийн 700 гаруй эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн ахисан түвшний сургалтад хамрагдсан байна.
2.4	Гадаадын өндөр хөгжилтэй оронд эмч, сувилагч, мэргэжилтнүүдийн сургалт ад хамруулах	Өндөр хөгжилтэй оронд зохион байгуулагдсан сургалт	Өндөр хөгжилтэй оронд зохион байгуулагдсан сургалтанд хамрагдсан эмч, сувилагч, мэргэжилтний тоо				• Мэдрэлийн мэс заслын тасгийн эрхлэгч М.Тэмүүжин ХБНГУ-д тархины дурангийн мэс заслын сургалтанд, Ангиографийн тасгийн эрхлэгч В.Гантулга БНСУ-д Мэдрэлийн судасны мэс заслын мастер класс сургалт, Мэдрэлийн мэс заслын тасгийн эмч Э.Анхбаяр Австри улсад Нурууны мэс заслын сургалт, БНСУ-д нуруу нугасны мэс заслын сургалт, 2022 онд ЭМС-ын А\185 дугаар тушаалаар баталсан "Гадаадын өндөр хөгжилтэй оронд сургах тэргүүлэх чиглэл"-ийн дагуу "Зүрхний хавхлага солих судсан дотуурх мэс засал" чиглэлээр Зүрх судас судлалын тасгийн эмч Б.Батболд, Д.Амарзул, сувилагч Д.Батцэцэг нар БНСУ-д Ёонсей их сургуулийн Северенс эмнэлэгт, Гэмтэл согог, ортопедийн тасгийн зөвлөх эмч Б.Батзориг Канад улсад өвдөг түнхний хиймэл үений халдварын дараах давтан мэс заслын сургалтад, БНСУ-ын Олон Улсын Эрүүл Мэндийн Сангийн Dr.Lee Jong Wook-ын тэтгэлэгт сургалтад Цөмийн оношилгоо, эмчилгээний PET/CT хариуцсан инженер О.Тэмүүлэн, Цацраг идэвхит эмийн үйлдвэрлэлийн технологич Т.Уянга, Цөмийн онош зүйн эмч Э.Мандуул, уушги судлалын тасгийн эмч Д.Бямбадолгор, яаралтай тусламжийн тасгийн эмч Г.Янжинлхам нар, Мэдрэл судлалын тасгийн эмч Д.Уянга БНСУ-д мэдрэл судлалын сургалтад, Ерөнхий мэс заслын тасгийн эмч Б.Ган-Эрдэнэ, Н.Тайван нар БНСУ-д нойр булчирхай шилжүүлэн суулгах мэс заслын сургалтад, БНСУ-ын Олон Улсын Эрүүл Мэндийн Сан, Улсын хоёрдугаар төв эмнэлэг болон Канбуг Самсунг эмнэлгийн хамтын ажиллагааны гэрээний дагуу “Монгол Улсын

							Үндэсний оношилгоо эмчилгээний төвийн үйл ажиллагааны менежментийн 2-р шатны консалтинг” төслийн хүрээнд 7 албаны 21 мэргэжилтэн, удирдах ажилтанг 5 удаагийн урт болон богино хугацааны сургалтад нийт 36 мэргэжилтэн 5 улсад сургалтад мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байна. ЭМС-ийн 2022 оны А\185 дугаар тушаалаар баталсан төгсөлтийн дараах гадаад сургалтын тэргүүлэх чиглэлийн жагсаалтад байгаа “Судсан дотуур зүрхний хавлага солих мэс засал” богино хугацааны сургалтад БНСУ-ын Йонсэй сэвэрэнс эмнэлэгт ЗССТ-ийн эмч Б.Батболд, Д.Амарзул, сувилагч Б.Батцэцэг нар 10-р сарын 26-наас 12-р сарын 26-ны өдрийг хүртэл 2 сарын хугацаатай суралцаж байна.
2.5	Залуу боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах үүднээс ажил үүргийн дагуу мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх	Эзэмшсэн мэргэжлийн дагуу мэдлэг, чадвар дээшилсэн байна	Дэмжлэг үзүүлсэн залуу боловсон хүчний тоо Сургалтад хамруулсан залуу боловсон хүчний тоо				Хүүхдийн мэдээгүйжүүлэг судлалаар Мэдээгүйжүүлэг эрчимт, эмчилгээний тасгийн эмч Г.Гантөмөр, Эмэгтэйчүүдийн хавдрын мэс заслын чиглэлээр Эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн эрхлэгч Т.Баярчимэг, Бүдүүн, шулуун гэдэсний мэс заслын чиглэлээр Ерөнхий мэс заслын тасгийн эмч Б.Эрдэнэбадрал, Цээжний хөндийн мэс заслын чиглэлээр Б.Амартүвшин нар мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан. Сургалтын хугацаанд үндсэн цалинг 100% олгосон. Төгсөлтийн дараах сувилахуйн төрөлжсөн болон дээшлүүлэх сургалтад нийт 28 сувилагч суралцснаас төрийн сангийн зардлаар 13 сувилагч суралцсан. Үүнд: - Дархлаажуулалтын сувилахуй-1. - Мэдрэлийн сувилахуй-1 - Мэс заслын сувилахуй-10 - Эрчимт эмчилгээний сувилахуй-3 - Яаралтай тусламжийн сувилахуй-5 - Мэдээгүйжүүлгийн сувилахуй-3 - Оношилгооны дурангийн сувилахуй-5 Сургалтын хугацаанд үндсэн цалинг 100% олгосон. - Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер Г. Ган-Эрдэнэ Гемодиализын техникчийн сургалтанд хамрагдсан. Сургалтын хугацаанд үндсэн цалинг 100% олгосон.

								- Хавдар судлалын үндэсний төвд Эм зүйч Б.Жавзансүрэн,, эм найруулагч Н.Баярмаа, сувилагч Э.Сэрсмаа нарыг дадлага сургалтанд 1 сарын хугацаатай хамруулсан. Сургалтын хугацаанд үндсэн цалинг 100% олгосон. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендерийн хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтад 20 эмнэлгийн мэргэжилтний сургалтын төлбөрийг байгууллагаас гарган суралцуулсан (Эмнэлгийн ерөнхий захирлын А/26,А/148 тушаал)
2.7	Их эмчийн мэргэшүүлэх сургалт удирдах эмнэл зүйн сургагч багшийн сургалтыг өргөжүүлэн эмнэл зүйн чиглүүлэгч багшийн тоог нэмэгдүүлж, сувилахуйн мэргэшүүлэх сургалтыг удирдах сувилагч-сургагч багшийг үе шаттайгаар сургах	Их эмч болон сувилагчийн мэргэшүүлэх сургалт удирдах эмнэлзүйн сургагч багш	Их эмч болон сувилагчийн мэргэшүүлэх сургалт удирдах эмнэлзүйн сургагч багшийн сургалтанд хамрагдсан мэргэжилтний тоо					Эмнэлзүйн сургагч багшаар 6 эмч, 1 эм зүйч, 1 сувилагчийг шинээр бэлтгэснээр УХТЭ-т нийт 38 эмнэлзүйн сургагч багштай болсон байна.
2.8	Байгууллагын шаардлагаар төгсөлтийн дараахь мэргэшүүлэх сургалтад хамрагдах эмнэлгийн мэргэжилтэнд сургалтын хугацааны тэтгэмжтэй чөлөө олгох	Суралцсан эмнэлгийн мэргэжилтэн	Эмнэлгийн ерөнхий захирлын тэтгэмжтэй чөлөө олгосон тушаал Сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо					Хүүхдийн мэдээгүйжүүлэг судлалаар Мэдээгүйжүүлэг эрчимт, эмчилгээний тасгийн эмч Г.Гантөмөр, Эмэгтэйчүүдийн хавдрын мэс заслын чиглэлээр Эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн эрхлэгч Т.Баярчимэг, Бүдүүн, шулуун гэдэсний мэс заслын чиглэлээр Ерөнхий мэс заслын тасгийн эмч Б.Эрдэнэбадрал, Цээжний хөндийн мэс заслын чиглэлээр Б.Амартүвшин нар мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан. Сургалтын хугацаанд үндсэн цалинг 100% олгосон. Төгсөлтийн дараах сувилахуйн төрөлжсөн болон дээшлүүлэх сургалтад нийт 28 сувилагч суралцснаас төрийн сангийн зардлаар 13 сувилагч суралцсан. Үүнд: • Дархлаажуулалтын сувилахуй-1. • Мэдрэлийн сувилахуй-1 • Мэс заслын сувилахуй-10 • Эрчимт эмчилгээний сувилахуй-3 • Яаралтай тусламжийн сувилахуй-5

								• Мэдээгүйжүүлгийн сувилахуй-3 • Оношилгооны дурангийн сувилахуй-5 Сургалтын хугацаанд үндсэн цалинг 100% олгосон. • Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер Г. Ган-Эрдэнэ Гемодиализын техникчийн сургалтанд хамрагдсан. Сургалтын хугацаанд үндсэн цалинг 100% олгосон. • Хавдар судлалын үндэсний төвд Эм зүйч Б.Жавзансүрэн,, эм найруулагч Н.Баярмаа, сувилагч Э.Сэрсмаа нарыг дадлага сургалтанд 1 сарын хугацаатай хамруулсан. Сургалтын хугацаанд үндсэн цалинг 100% олгосон. • Мэдрэлийн мэс заслын тасгийн эрхлэгч М.Тэмүүжин ХБНГУ-д тархины дурангийн мэс заслын сургалтанд, Ангиографийн тасгийн эрхлэгч В.Гантулга БНСУ-д Мэдрэлийн судасны мэс заслын мастер класс сургалт, Мэдрэлийн мэс заслын тасгийн эмч Э.Анхбаяр Австри улсад Нурууны мэс заслын сургалт, БНСУ-д нуруу нугасны мэс заслын сургалт, 2022 онд ЭМС-ын А\185 дугаар тушаалаар баталсан "Гадаадын өндөр хөгжилтэй оронд сургах тэргүүлэх чиглэл"-ийн дагуу "Зүрхний хавхлага солих судсан дотуурх мэс засал" чиглэлээр Зүрх судас судлалын тасгийн эмч Б.Батболд, Д.Амарзул, сувилагч Д.Батцэцэг нар БНСУ-д Ёонсей их сургуулийн Северенс эмнэлэгт, Гэмтэл согог, ортопедийн тасгийн зөвлөх эмч Б.Батзориг Канад улсад өвдөг түнхний хиймэл үений халдварын дараах давтан мэс заслын сургалтад, БНСУ-ын Олон Улсын Эрүүл Мэндийн Сангийн Dr.Lee Jong Wook-ын тэтгэлэгт сургалтад Цөмийн оношилгоо, эмчилгээний PET/CT хариуцсан инженер О.Тэмүүлэн, Цацраг идэвхит эмийн үйлдвэрлэлийн технологич Т.Уянга, Цөмийн онош зүйн эмч Э.Мандуул, уушги судлалын тасгийн эмч Д.Бямбадолгор, яаралтай тусламжийн тасгийн эмч Г.Янжинлхам нар, Мэдрэл судлалын тасгийн эмч Д.Уянга БНСУ-д мэдрэл судлалын сургалтад, Ерөнхий мэс заслын тасгийн эмч Б.Ган-Эрдэнэ, Н.Тайван нар БНСУ-д нойр булчирхай шилжүүлэн суулгах мэс заслын сургалтад, БНСУ-ын Олон Улсын Эрүүл Мэндийн Сан, Улсын хоёрдугаар төв эмнэлэг болон Канбуг Самсунг эмнэлгийн хамтын ажиллагааны гэрээний дагуу "Монгол Улсын Үндэсний оношилгоо эмчилгээний төвийн үйл ажиллагааны менежментийн 2-р шатны консалтинг" төслийн
--	--	--	--	--	--	--	--	---

								хүрээнд 7 албаны 21 мэргэжилтэн, удирдах ажилтанг 5 удаагийн урт болон богино хугацааны сургалтад нийт 36 мэргэжилтэн 5 улсад сургалтад мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байна. Сургалтанд хамрагдах хугацаанд үндсэн цалинг 100% олгосон.
2.9	Лавлагаа шатлалын эмнэлгийн эмч, мэргэжилтнийг анагаах ухааны судалгааг бүрэн эхээр нь ашиглах боломжийг бүрдүүлэх	Анагаах ухааны судалгааг бүрэн эхээр нь ашиглах эрх	Олон улсын эмч нарын мэргэжлийн нийгэмлэгүүдийн гишүүнчлэл					- Гадаадын өндөр хөгжилтэй 10 гаруй орнуудын эмнэлэг, төрийн бус байгууллагуудтай идэвхтэй хамтын ажиллагаатай ажиллаж байна. Үүнд: ➢ БНСУ-ын Йонсэй Сэвэрэнс эмнэлэг ➢ БНСУ-ын Канбуг Самсунг эмнэлэг ➢ БНСУ-ын Кореа Ансан ➢ БНСУ-ын Анам эмнэлэг ➢ БНСУ-ын Вельсийн нэрэмжит эмнэлэг ➢ БНСУ-ын Бусаны их сургуулийн эмнэлэг ➢ БНСУ-ын Дүрс оношилгоо эрүүл мэндийн шинжлэх ухааны хүрээлэн (KIRAMS) ➢ БНСУ-ын Гёнгиду аймгийн Олон улсын эрүүл мэндийн нийгэмлэг ➢ Тайвань улсын Тайпэй байгууллага ➢ Турк улсын Мэдикал Парк эмнэлэг. Мөн гадаад хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-ын KOFIH (Korea Foundation for International Healthcare) байгууллагын санхүүжилттэй 2025 он хүртэл хэрэгжих төслийг Канбуг Самсунг эмнэлэгтэй хамтран амжилттай хэрэгжүүлж байна - Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн эрдэм шинжилгээний хурал нь “Сувилагчдын бие даасан байдал, сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулъя” сэдвийн дор 05 дугаар сарын 14-ны өдөр зохион байгуулагдаж, 15 илтгэлийг амаар, 6 илтгэлийг e-poster-оор амжилттай хэлэлцүүлж, шилдэг илтгэлийг шалгарууллаа. “Резидент эмч нарын эрдэм шинжилгээний хурал-2022”-ыг 06 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан бөгөөд 14 илтгэлийг амаар, 14 илтгэлийг e-poster-оор амжилттай

							хэлэлцүүлж, шалгарсан илтгэгчдэд эмнэлгийн эрдэм шинжилгээний хуралд орох эрхийг өгөв. 44 дэх удаагийн эрдмийн чуулганыг ЭМЯ-наас 2022 оныг “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах жил” болгон зарласан ажлын хүрээнд “Оновчтой менежемент-Чанартай тусламж, үйлчилгээ” сэдвийн дор 2022 оны 10 дугаар сарын 29-ний өдөр амжилттай зохион байгуулж, 32 аман илтгэл, ханын 19 илтгэлийг хэлэлцүүлж, шилдэг илтгэлийг шалгарууллаа.
2.1 0	Эрүүл мэндийн байгууллагад ажилтныг ажилд авах, сонгон шалгаруулах үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулах нийтлэг журмыг шинэчлэн баталж, мөрдүүлэх	Эмнэлгийн захирлын Эрүүл мэндийн ажилтан сонгон шалгаруулж, ажилд авах журам	Нээлттэй, ил тод сонгон шалгаруулалт зарласан байдал Журмын дагуу сонгон шалгаруулах үйл ажиллагаа Сонгон шалгаруулалтан д тэнцсэн ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулсан байдал				https://info.shilendans.gov.mn/login “Шилэн данс”-д байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг сар бүр тайлагнасан. - Эмнэлгийн ЦАХИМ хуудасны http://ssch.gov.mn/ “АЖЛЫН БАЙРНЫ ЗАР” буланд 132 удаа нийт 48 ажлын байрны зар, эмнэлгийн Facebook page-д 81 удаа 48 ажлын байрны зарыг байршуулсан - Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд 3 ажлын байрны захиалга өгсөн. - Монгол Улсын хэрэгжүүлэгч агентлаг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын мэргэжилтэн н.Дорждэрэмтэй хамтран ажиллаж үйлчлэгч, цахим бүртгэл лавлагааны ажилтны ажлын байранд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд авах санал, хүсэлтийг хүргүүлсэн. - Ажилд орохыг хүссэн эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтанг Эмнэлгийн Ерөнхий захирлын тушаалаар батлагдсан “Сонгон шалгаруулах журам”-ын дагуу Удирдлагын зөвлөлийн хурал болон тасгийн хамт олны хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр ил тод, нээлттэйгээр сонгон шалгаруулж ажилд авч, 2022 онд 113 ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан
2.1 1	Байгууллагын шинээр ажилд орсон эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтанд чиглүүлэх сургалт явуулах тухай журам батлуулан хэрэгжүүлэх	Эмнэлгийн ерөнхий захирлын баталсан журам	Батлагдсан журам				УХТЭ-т шинээр ажилд орсон эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэнд эмнэлгийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа, хөдөлмөрийн дотоод журам, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, халдварын сэргийлэлт зэрэг сэдвийн хүрээнд зааж, чиглүүлэх зорилготой сургалтыг 09 дүгээр сарын 06-ны

							өдөр Захиргаа, хүний нөөцийн алба, Сургалт гадаад харилцааны алба, Сувилахуйн алба хамтран зохион байгууллаа. Тус сургалтад шинээр ажилд орсон нийт 18 хүн хамрагдсан бөгөөд 12 сэдвийн хүрээнд ажил үүргээ гүйцэтгэхэд нэн шаардлагатай анхан шатны мэдлэг, мэдээллээ бүрэн олж авсан байна. "Өртөлт, өртөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээ" сэдэвт 1 сарын аян зохион байгуулсан. Аяны эмнэлгийн хэмжээнд өртөлт хариуцсан 50 ажилтан бэлтгэгдсэн. "Эрүүл мэндийн ажилтны өртөлт" сэдэвт сургалтыг нийт 50 эрүүл мэндийн ажилтанд 2 удаа зохион байгуулсан. 5 дугаар сарын 4-ны өдөр 1 удаа, 06 дугаар сарын 23-ны өдөр Солонгосын KOFIN төслийн санхүүжилтээр 25 сувилагч, 5 резидент эмч нарт сургалт зохион байгуулагдсан. ӨДС-ийн цомгийн жагсаалт, хөтлөх маягт хуудас, зааврыг эмнэлгийн хэмжээнд ижил болгож тасгуудад хүргүүлсэн. Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх, өртөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээ сэдвээр 2 удаагийн давтамжтай 50 эрүүл мэндийн ажилтанд танхмийн сургалт зохион байгуулсан. Мэдлэг үнэлэх 10 асуумж бэлтгэн эрүүл мэндийн ажилтанг сургалтын өмнө болон дараа тестийн үнэлгээнд хамруулсан. Өртөлт сэдвээр сургалтын өмнө 22 эрүүл мэндийн ажилтны мэдлэгийг үнэлэхэд дундаж үнэлгээ 52.1% байв. Шинэ ажилтны чиглүүлэх сургалтыг жил бүр тасралтгүй зохион байгуулагддаг бөгөөд үүнд гарын эрүүл ахуй, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн ажилтан өртсөн үед авах арга хэмжээ, халдвартай хог хаягдал ангилан ялгах тушаал заавар, эрүүл мэндийн ажилтны дархлаажуулалт зэрэг сэдвүүдээр зохион байгуулагддаг. 2022 оны байдлаар 80 эрүүл мэндийн ажилтан шинээр ажилд орсон ба чиглүүлэх сургалтанд 80 хамрагдсан.
2.1 2	Байгууллага нь ажилтан бүрийн ойрын болон дунд хугацаанд өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний дагуу ур чадвар, туршлагыг үнэлж, тэднийг сургах, хөгжүүлэх	Эрүүл мэндийн сайдын тушаал	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны төлөвлөгөө				- Эмнэлгийн удирдах албан тушаалтнуудын харилцаа хандлага, байгууллагын соёлыг дээшлүүлэх, удирдах ёс зүй манлайллыг сайжруулах зорилготой сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 11-ний өдөр "Тайж ресорт" хурлын танхимд зохион байгуулсан. 2022 оны 4 дүгээр сарын 8-нд АУ-ны доктор, сэтгэл заслын эмч, сэтгэцийн эрүүл мэндийн нийгэмлэгийн нарийн бичгийн

	нэгдсэн төлөвлөгөөг жил бүр гарган хэрэгжүүлэх							дарга Н.Алтанзул “Стресс менежмент ба харилцаа” сэдвээр нийт эмч нарт лекц уншсан. • 2022 оны 4 дүгээр сарын 22-нд Монгол Кампус Крусейд фор Крайст байгууллагын эмч, сувилагч, эмч нарын салбарын удирдагч Д.Төгөлдөр эмнэлгийн нийт эмч нарт “Бид харилцаанд бэлэн үү” сэдэвт хувь хүний хөгжлийн лекц уншсан. • Эрдэм шинжилгээ, инноваци, хөгжлийн бодлого хариуцсан дэд захирал Д.Цогт-Очир 2022 оны 5 сарын 12, 20-ны өдрүүдэд эмнэлгийн мэргэжилтнүүдэд “Байгууллагын соёл, харилцаа” сэдвээр лекц уншсан. • Төлөвлөгдсөн өглөөний сургалтууд бүрэн зохион байгуулагдсан байна. Төв, эмнэлзүйн тасгууд 03 сараас эхлэн долоо хоног бүрийн пүрэв гариг бүрд “Өглөөний хэлэлцүүлэг” хийж байна. Одоогоор 25 удаа тасгууд өглөөний хэлэлцүүлэг хийсэн байна.
2.1 3	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг болон анхан шатлалын эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байранд дадлагажуулан сургах, төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг үзүүлэх	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг болон анхан шатлалын эмнэлэгт зөвлөгөө өгсөн байдал	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг болон анхан шатлалын эмнэлэгт зөвлөгөө өгсөн байдал					УХТЭ нь Үндэсний оношилгоо эмчилгээний төв болон өргөжиж, лавлагаа тусламж, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж байгаа тул бусад төрөлжсөн эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, ӨЭМТ, СЭМТ-ийн эмч нарт зориулсан 9 удаагийн багц цагийн сургалтыг танхим, цахим хосолсон хэлбэрээр 2022 онд зохион байгуулсан. Үүнд: ➢ СЗЭТ-аас “Өвдөгний үеийн остеоартритын сэргээн засах эмчилгээний орчин үеийн чиг хандлага”, “Мөрний эмгэгийн үеийн менежмент” – 2 удаа ➢ БДШТ-аас “Жирэмсэн эмэгтэйчүүдийн бөөрний өвчлөл”, “Тогтолцооны яршил өвчний орчин үеийн чиг хандлага”, “Бөөрний эмгэгтэй өвчтөнийг үнэлж сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэх нь”- 3 удаа ➢ ЗССТ-аас “Зүрхний архаг өвчний оношилгоо, эмчилгээ” ➢ ММЗТ-аас БНСУ-ын Гёнгү аймгийн Вельсийн нэрэмжит эмнэлэгтэй хамтран “Бүсэлхий нурууны өвдөлтийн оношилгоо, эмчилгээний орчин үеийн чиг хандлага”

								➤ Эм зүйн албанаас “Нянгийн эсрэг эмийн эмчилгээний өнөөгийн байдал эрсдэлт бүлгийн эмчлүүлэгчдэд хэрэглэх онцлог олон эмэнд тэсвэртэй нянгийн тэсвэржилт” ➤ БДШТ-аас АНУ-ын Johns Hopkins University-ийн эмч Prof. Atta Mohamed.Ph.D-тай хамтран “Бөөрний түүдгэнцэрийн өвчний оношилгоо, эмчилгээний шинэ удирдамж”, “Гемодиализ эмчилгээний зарим хүндрэлийн оношилгоо, эмчилгээний орчин үеийн чиг хандлага” ➤ “Эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага, ёс зүйн хэм хэмжээ”- зөвхөн УХТЭ-ийн эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнг хамруулсан. Сургалт бүрийн мэдээллийг УХТЭ-ийн пэйж хуудаст https://www.facebook.com/ssch.gov.mn нийтэлсэн. ● Зүүн бүсийн таван аймаг болох Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь болон Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг Багануур, Налайх, Багахангай дүүргийн Нэгдсэн эмнэлгүүдтэй гурван жилийн хугацаатай санамж бичигт гарын үсэг зурж, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн зүүн бүсийн 5 аймаг, алслагдсан 3 дүүргийн 700 гаруй эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн ахисан түвшний сургалтад хамрагдсан байна ● Зүүн 5 аймаг, алслагдсан 3 дүүрэгт 3 долоо хоногийн турш 3 багаар 30 гаруй эмч, мэргэжилтнүүдийнхээ хамт 4000 км гаруй урт замыг туулан хамтарсан сургалт, хамтарсан хагалгаа, телемедициний холболт гэсэн ажлуудыг төлөвлөн ажиллаа. ● Орон нутгийн 300 орчим эмч мэргэжилтнүүдэд 8 төрлийн мэдлэг олгох лекц уншнаас гадна 20 гаруй ахисан түвшний хагалгааг амжилттай хамтран хийлээ. ● Багануур дүүргийн ЭМТ-ийн чанарыг баг 14 хоногийн дадлага сургалтыг УХТЭ-т хийсэн. ● Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлгийн дүрс оношилгооны эмч дурангийн оношилгооны 21 хоногийн эмнэлзүйн дадлага сургалтыг УХТЭ-ийн Дурангийн төвд хийж байна.
--	--	--	--	--	--	--	--	--

Зорилт 3. Санхүүгийн болон санхүүгийн бус урамшууллын шинэ аргыг нэвтрүүлж, эрүүл мэндийн ажилтны бодит орлого, ажиллах урам зоригийг нэмэгдүүлэх

3.1	Эмнэлгийн мэргэжилтний хөдөлмөрийн норм, нормативыг тооцох аргачлалын дагуу норм, нормативыг тооцох	Эмнэлгийн мэргэжилтний хөдөлмөрийн норм, норматив	Батлагдсан аргачлалыг судлах, эзэмших, хэрэгжүүлэх					2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан А/185, А/252 тушаалын дагуу Эмнэлгийн мэргэжилтний ажлын ачаалал тооцох, хөдөлмөрийн норм, норматив тогтоох тухай аргачлыг судлаж байна.
3.2	Эрүүл мэндийн ажилтны гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг боловсронгуй болгох	Эрүүл мэндийн сайдын баталсан гүйцэтгэлийг үнэлэх шалгуур	Гүйцэтгэлийн үнэлгээний дагуу олгосон урамшуулалын хэмжээ					Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05, 395 дугаар тогтоолоор тус тус батлагдсан “Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшил олгох журам”-ын дагуу Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бүрийн ажлын гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу алба, тасгийн хамт олноор ил тодоор үнэлүүлдэг ба 2022 оны I улиралд 507 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 180,327,968 төгрөг, 2022 оны II улиралд 509 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 191,285,364 төгрөг, 2022 оны III улиралд 506 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 165,355,960 төгрөг, олгогдсон. (Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны Б/164, Б/249, А/104 тушаалууд)
3.3	Эрүүл мэндийн ажилтны нэмэгдэл хөлсний талаар мөрдөж буй эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтэд тогтмол хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудит хийх	Эрүүл мэндийн ажилтны нэмэгдэл хөлсний талаар мөрдөж буй эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудит	Жил бүрийн аудитын тайлан, зөвлөмж					- Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 25, 276, 107 дугаар тогтоолын дагуу Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны А/37, А/89, А/90 дүгээр тушаалаар нийт ажилтны үндсэн цалинг 10%-иар нэмэгдүүлсэн. Ингэснээр илүү цаг, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшууллын хувь өсөж ажилтны гарт олгогддог цалин 15-40 хувиар нэмэгдэж байна. - Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 22.1 дэх заалтын дагуу эмнэлгийн хэмжээнд Анагаах ухааны доктор 11, Зөвлөх эмч 12, Зөвлөх сувилагч 2, Тэргүүлэх эмч 38, Тэргүүлэх сувилагч-39, Ахлах эмч 29, Ахлах сувилагч 41, бусад мэргэжилтэн 4 нийт 176 ажилтанд боловсролын болон зэргийн нэмэгдлийг үндсэн цалингийн 10-20 хувиар тус тус тооцон 200,617,117 төгрөгийн нэмэгдэл олгосон - Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны

								151 дүгээр тогтоолын дагуу төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл нийт 296 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 313,875,346 төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон. • Хөдөлмөрийн тухай хуулийн 108.1 дүгээр заалт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалын дагуу хөдөлмөрийн хэвийн бус нөхцлийн нэмэгдэл 147,628,418 төгрөгийг 187 эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон. • Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн дагуу илүү цагаар болон 7 хоногийн амралт, нийтээр амрах баяр ёслолын өдөр ажиллуулсны хөлс болох 1,581,542,311 төгрөгийг давхардсан тоогоор нийт 2,970 эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон. • Дуудагдан ажилласны хөлс болох 80,130,160 төгрөгийг давхардсан тоогоор нийт 1,796 эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон. • Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх заалт, Эмнэлгийн ерөнхий захирлын 2020 оны А/59 дугаар тушаалын дагуу Шөнийн цагт ажилласны нэмэгдэл 138,924 цагийн 138,924,000 төгрөг олгогдсон. • Алсын болон төрөлжсөн мэргэжлийн дуудлагаар явж эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэний нэмэгдэл хөлс- (Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлэг, Дорнод аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Багахангай дүүрэг) Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт 8 эмнэлгийн мэргэжилтэн ажилтанд 372,876 төгрөг олгосон. • Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 06 дугаар тогтоолын хавсралтын дагуу хоол, унааны нэмэгдэл 502,593, 000 төгрөгийг 546 ажилтанд олгосон. • Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05, 395 дугаар тогтоолоор тус тус батлагдсан “Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшил олгох журам”-ын дагуу Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бүрийн ажлын гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу алба, тасгийн хамт олноор ил тодоор
--	--	--	--	--	--	--	--	--

								үнэлүүлдэг ба 2022 оны I улиралд 507 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 180,327,968 төгрөг, 2022 оны II улиралд 509 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 191,285,364 төгрөг, 2022 оны III улиралд 506 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 165,355,960 төгрөг, 2022 оны IV улиралд 501 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 212,025,308 төгрөг олгогдсон. (Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны Б/164, Б/249, А/104, А/155 тушаалууд) - Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтад заасны дагуу ур чадварын нэмэгдлийг 35 ажилтанд 10%-иар тооцон нийт 22,870,655 төгрөг тооцон олгосон. - Хариуцлагын нэмэгдлийг 50 ажилтанд нийт 46,229,433 төгрөг тооцон олгосон. - Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хөдөлмөрийн чадвар алдсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, эсхүл тахир дутуугийн тэтгэвэр тогтоогдох эрх үүсэх хүртэл нь нийт 504 (3358 нийт хоногийн) эмнэлгийн эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтанд Ажил олгогчоос 59,505,348 төгрөг, Нийгмийн даатгалын сангаас 34,869,349 төгрөгийн тэтгэмж олгосон. - Эмнэлэг сувилахуйн болон тусгай мэргэжилтний хомсдолд орж ажлын байрны ажлын ачаалал эрс нэмэгдсэнтэй холбоотой Ерөнхий захирлын 2022 оны А/99 дугаар тушаалаар 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн сувилахуйн болон тусгай мэргэжилтнүүдэд үндсэн цалингийн 15 хувийн нэмэгдлийг олгон ажиллаж байна. - Хангамж, үйлчилгээний хэсгийн үйлчлэгчийн ажлын байранд ажиллах ажилтны хомсдол үүсч, батлагдсан орон тооноос нэн дутуу ажиллан нэг үйлчлэгчид ноогдох ажлын ачаалал эрс нэмэгдсэн тул Ерөнхий захирлын 2022 оны Б/313 дугаар тушаалаар 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үндсэн цалингийн 20%-ийн нэмэгдэл олгон ажиллаж байна.
3.4	Зээл хүссэн эрүүл мэндийн ажилтанд бага хүүтэй цалингийн	Банктай хийсэн гэрээ	Зээл авсан ажилчдын тоо, мөнгөн дүн					2022 онд эмнэлгийн ажилтны хэрэглээний зээлийн баталгааг баталгаажуулах зорилгоор ХАС банктай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу 317 эмнэлгийн мэргэжилтэн,

	болон хэрэглээний зээл олгоход банк, санхүүгийн байгууллагатай хэрэглээний хамтран ажиллах							ажилтанд 2,185,000,000 төгрөгийн цалингийн зээл олгоход байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлсэн.
								Худалдаа хөгжлийн банкны сансар салбартай хамтран орон сууцны 6%-ийн зээл болон цалингийн багц бүтээгдэхүүний талаар өдөрлөгийг 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдөр эмнэлэг дээрээ зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр 115 ажилтанд орон сууцны зээлийн зөвөлгөө, 20 ажилтанд банкны карт захиалгын үйлчилгээ үзүүлсэн.
3.5	Эрүүл мэндийн ажилтны төрсөн аав, ээж, эхнэр (нөхөр), үр хүүхэд зэрэг гэр бүлийн гишүүнд байгууллагын түвшинд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх	Хөнгөлөлттэй тусламж, үйлчилгээ	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлсэн эрүүл мэндийн ажилтны гэр бүлийн гишүүдийн тоо					- Монгол улсын хөдөлмөрийн баатар, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ахмад ажилтан, 75-с дээш настай ахмадуудад хэвтэн эмчлүүлэхгүйгээр, яаралтай бус журмаар амбулаторийн үзлэг, оношилгоо, эмчилгээ, зөвлөгөө, хяналт болон эрүүл мэндийн боловсрол олгох дотрын эмчийн үзлэгийн кабинетыг 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс нээн ажиллуулж байна. (Эмнэлгийн ерөнхий захирлын А/116 дугаар тушаал) - Хүүхдийн тасаг нь эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны 448 хүүхдэд амбулатори болон стационарийн тусламж үзүүлсэн ба үүнээс 98 нь стационарийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн. Мөн түүнчлэн эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны 0-2 насны 39 хүүхдийг дархлаажуулалтанд хамруулсан
Зорилт 4. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын чиглэлийн судалгаа, бүртгэл мэдээллийг сайжруулж, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах үйл ажиллагааг дэмжин, оролцогч талуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх								
4.1	Эрүүл мэндийн ажилтнуудын тоо, байршил, хуваарилалт, хүртээмж, төгсөлтийн дараахь сургалтад хамрагдалт, шилжилт хөдөлгөөний статистик мэдээллийг жил бүр холбогдох байгууллагад хүргүүлэх	Хүний нөөцийн мэдээний нэгдсэн сан	Хүний нөөцийн статистик мэдээлэл, тайлан					2022 онд 28 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байрны зохицуулалт хийж, түр болон урт хугацаагаар сэлгүүлэн, шилжүүлэн ажиллуулсан. (Ерөнхий захирлын 2022 оны Б/22, Б/23, Б/51, Б/55, Б/109, Б/121, Б/154, Б/177, Б/220, Б/241, Б/339, Б/354, Б/384, Б/425 дугаар тушаал) - Төрийн албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах бусад мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрт өөрчлөлтийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд үнэн зөв байдлаар оруулж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна. 2020 оны 10 дугаар сараас эхлэн Хүний нөөцийн удирдлагын систем

								(ХНУС) дэх өгөгдлийн дагуу ажилтнуудын тоо, байршил, хуваарилалтыг тухай бүр шинэчлэн нэгдсэн сан үүсгэн ажиллаж байна. • Эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй сувилагчдын хүний нөөцийн судалгаа, эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн төлөвлөлтийн урьдчилсан судалгааг 2022 оны 8 дугаар сард гарган ЭМЯ-нд хүргүүлсэн • Улаанбаатар хотын авто замын түгжрэлтэй холбоотой эмнэлгийн цэцэрлэг, бага ангийн хүүхдийн судалгаа, эмнэлгийн алба хаагчид ажилд ирэхдээ ямар тээврийн хэрэгслээр ирдэг судалгааг 2022 оны 9 дүгээр сард нэгтгэн ЭМЯ-нд хүргүүлсэн • 2022 оны 09 дүгээр сард орон сууцны зээлд хамрагдах хүсэлтэй эмнэлгийн ажилтнуудын судалгаа явагдаж, нийт 346 ажилчид хамрагдсан байна.
4.2	Эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрийн чадвар түр алдалт, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлтэй холбоотой мэдээллийг эрүүл мэндийн албан ёсны бүртгэлтэй байх	Шинэчлэгдсэн статистик мэдээллийн маягт	Эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрийн чадвар түр алдалт, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлтэй холбоотой мэдээ					Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хөдөлмөрийн чадвар алдсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, эсхүл тахир дутуугийн тэтгэвэр тогтоогдох эрх үүсэх хүртэл нь нийт 504 (3358 нийт хоногийн) эмнэлгийн эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтанд Ажил олгогчоос 59,505,348 төгрөг, Нийгмийн даатгалын сангаас 34,869,349 төгрөгийн тэтгэмж олгосон.
4.3	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын чиглэлийн судалгааг тогтмолжуулж, өргөжүүлэх	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын чиглэлийн судалгаа	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын чиглэлийн судалгааны тайлан					Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын чиглэлийн шаардлагатай “Өрх гэр бүл толгойлсон эмэгтэйчүүдийн судалгаа”, “Эрүүл мэндийн ажилтны орон сууцны судалгаа”, “Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хөдөлмөрийн чадвар алдсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, эсхүл тахир дутуугийн тэтгэвэр тогтоогдох эрх үүсэх хүртэлх эрүүл мэндийн ажилтны судалгаа”, “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын халдвараар өвдсөн эрүүл мэндийн ажилтны судалгаа”, “Эрүүл мэндийн ажилтны дархлаажуулалтын судалгаа”, “Өртөлтийн судалгаа” гэх мэт судалгааг тогтмолжуулсан.

								Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07-р сарын 01 өдрийн А/346 тоот тушаал гарсантай холбоотойгоор эмнэлгийн байгууллага нь эмч, эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн үнэлгээг байгууллагын онцлогт тааруулан боловсруулан гаргах болсонтой холбоотойгоор 7 бүлэг, 21 асуулттай судалгаагаар цахим хэлбэрээр авлаа. Эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн судалгаа 2022 оны 4-р улиралд УХТЭ-ийн нийт 290 ажилчид хамрагдлаа. Сэтгэл ханамжийн судалгааг 3-р улирлын сэтгэл ханамжийн судалгаатай харьцуулан дүгнэхэд: ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ Эмч, эмнэлгийн ажилчдын 70% нь байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, үзэл баримтлалын талаар санал нийлж байгаа ба энэ нь өмнөх улирлаас 7%-иар өссөн байна. Байгууллагын одоогийн бүтэц зохион байгуулалтыг оновчтой гэж байгаа хариулт өмнөлх улирлаас 8%-иар өссөн байна. Байгууллагын нэгж хэсгүүдийн үйл ажиллагааг уялдаа холбоо сайтай гэж дүгнэх тал дээр “зарим нэг хэсэг нэгжүүдийн чиг үүргийг тодорхой болгож, уялдуулах шаардлагатай” гэсэн хариулт 1%-иар буурсан нь тасаг нэгжүүдийн үйл ажиллагааг ахин судлан, уялдаа холбоог сайжруулах хэрэгтэйг харуулж байна. Байгууллагын гадаад харилцаа нь аль чиглэлээр түлхүү хөгжих ёстой гэж та үзэж байна вэ гэсэн асуултанд удирдлага ажилтнуудыг хөгжүүлэх, санхүүгийн чадварыг дээшлүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулах зэрэг хариултууд нь өмнөх улирлын хувиас төдийлөн өөрчлөгдөөгүй ба 42% нь санхүүгийн чадварыг дээшлүүлэх хэрэгтэй гэсэн хариултыг сонгосон байна. ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР Үр дүн гүйцэтгэлийн чанар сайн хариултаар 6.5%-иар өсч, дунд гэсэн хариултаар 7%-иар буурч, маш муу хариулт нь 1%-иар өссөн байна.
--	--	--	--	--	--	--	--	--


								Үр дүн, үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэхийн тулд ажилтнуудын дэмжлэг тусалцаа, удирдлагын үйл ажиллагаа, хэсэг нэгжүүдийн уялдаа холбоо гэсэн хариултууд дээр дийлэнх хувийг эзэлж байгаа тул энэ тал дээр анхаарч ажилахыг харуулж байна. Байгууллагын үйл ажиллагааг чанаржуулахад юунд анхаарах нь чухал вэ гэсэн асуултанд ажлын үнэлгээ, идэвхжүүлэлт, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох гэсэн хариултыг 64% нь сонгосон байна. ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ТАЛААР Та тус байгууллагад ажиллаж байгаадаа сэтгэл хангалуун байж чаддаг уу гэсэн асуултанд өмнөх улирлаас 5%-иар өсч 63% нь тийм гэж хариулсан байна. Ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмж ямар төвшинд байна гэж та үзэж байна вэ? Гэсэн асуултанд “өндөр” гэсэн хариулт 9%-иар өсч, “дунд” гэсэн хариулт 5%-иар буурсан байна. Байгууллагаас дэвшүүлж буй зорилго, зорилтууд таны хүлээлт, сонирхол, хэрэгцээ, шаардлагатай нийцдэг үү? Гэсэн асуултанд 60% нь “зарим тохиолдолд” гэж хариулсан бол 16.5% нь “тийм” гэж хариулсан байна. ТАВ. БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН ТАЛААР Байгууллагын санхүүгийн чадварыг дээшлүүлэхийн тулд удирдлагын зүгээс юу хийх ёстой гэж та үзэж байна вэ? Гэсэн асуултаар “маркетингийн үйл ажиллагааг сайжруулах, санхүүгийн ил тод байдлыг бий болгох” гэсэн хариултуудыг дийлэнх нь сонгосон байна. Байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаандаа мэдээлэл, шинжилгээний нэгдсэн програмыг ашиглаж, нээлттэй тайлагнаснаар хамт олны идэвх, санаачлага дээшилнэ гэж та
--	--	--	--	--	--	--	--	--

							үзэж байна уу гэсэн асуултаар 68% нь дээшилнэ гэж хариулсан нь өмнөх улирлаас 5%-иар өссөн байна. ЗУРГАА. БАЙГУУЛЛАГЫН АЖЛЫН ОРЧНЫ ТАЛААР Байгууллагын техник, тоног төхөөрөмжийн худалдан авалт, хүрэлцээ хангамж, хэрэглээ ашиглалт “дунд зэрэг” гэдэг хариултаар 45% буюу өмнөх улирлаас 7%-иар өссөн бол “хангалттай” гэсэн хариулт нь өмнөх улирлаас 4%-иар өссөн байна. Ажилчдын ажиллах орчин бүрдсэн гэж та үзэж байна уу? Гэсэн асуултаар “бүрдсэн” гэх хариултаар 2% буурч 36.9% болсон бол “дунд зэрэг” гэх хариулт өмнөх улирлаас 8%-иар өсч 53% болсон байна. ДОЛОО. АЖИЛТНУУДЫН НИЙГМИЙН ХАНГАМЖ БА ХАЛАМЖ Ажилтнуудын нийгмийн хангамж, урамшуулал идэвхжүүлэлт ямар төвшинд байна гэж та үздэг вэ? Гэсэн асуултаар 61.2% нь “хангалтгүй”, 30% нь “дунд зэрэг” гэж үзсэн байна. Таны хувьд урамшуулал идэвхжүүлэлтийн ямар хэлбэрийг илүүд үзэх вэ? Гэсэн асуултаар 57.5% нь “цалингийн нэмэгдэл /ур чадвар, үр дүнгийн/”, 18% нь “байр, орон сууцтай болох”, 23% нь “ахуйн хэрэглээний нөхцөлөө сайжруулах” гэсэн хариултаудыг сонгосон байна. ЕРӨНХИЙ СЭТГЭЛ ХАНАМЖ Эмч, эмнэлгийн ажилчдын сэтгэл ханамжийн үнэлгээ нь 2022 оны 1-р улиралд “Сайн” гэсэн хариулт 24.6%, “Дунд” гэсэн хариулт 63.3% гэж гарсан бол 3-р улиралд “Сайн” гэсэн хариулт 45%, “Дунд” гэсэн хариулт 55% байсан бол 4-р улиралд “Сайн” гэсэн хариулт 68% буюу 23%-иар өсч, “Дунд” гэсэн хариулт 32% болж 23%-иар буурсан байна. Товч дүгнэхэд ажилчдын ёрөнхий сэтгэл ханамжийн хувь 23%-р дээшилсэн байна. АЖЛААС ГАРАГСДЫН СУДАЛГАА
--	--	--	--	--	--	--	---

(2022 он)


Судалгаанд нийт 50 ажилтан хамрагдсан бөгөөд 5/10%/ нь эрэгтэй, 45/90%/ нь эмэгтэй байв. Мэргэжлээр нь авч үзвэл 9/18%/ нь эмч, эмзүйч 27/54%/ нь сувилагч, тусгай мэргэжилтэн, бусад мэргэжлийн 14/28%/ ажилтан байсан. Мөн ажлаас гарах болсон үндсэн шалтгаан нь 45/90%/ өөрийн хүсэлтээр, 5/10%/ нь өндөр настны тэтгэвэрийн эрх үүссэн байсан.

Ажлаас гарагсдын УХТЭ-д ажилласан жил хувиар




Нийт ажлаас гарагсдын 10% нь 16-гаас дээш жил ажилласан, 8% нь 11-15 жил ажилласан, 12% нь 6-15 жилийн хугацаанд, 58% нь 1-5 жил, 12% нь 1 хүртлэх жил эмнэлэгт ажилласан буюу 70% нь 0-5 хүртлэх жил ажилласан ажилтнууд байна.

Ажлын сэтгэл ханамж




Нийт ажлаас гарагсдын 20% нь ажилдаа маш их сэтгэл хангалуун, 52% нь ажилдаа сэтгэл хангалуун, 26% нь 50/50, 2% нь сэтгэл хангалуун бус гэж хариулжээ.

Ур чадвар, нөөц боломж ашиглалт




Хийж байсан ажил тань таны үр чадвар, нөөц боломжийг сайн ашиглаж байсан бэ гэсэн асуултад оролцогчдын 32% нь бүрэн санал нийлж байна, 50% нь санал нэгтэй, 18% нь 50/50 гэж хариулжээ.

Шийдвэр гаргалтын оролцоо




Таны ажилд нөлөөлөх аливаа асуудлын шийдвэр гаргалтанд та оролцож байсан уу гэсэн асуултад 12% нь бүрэн санал нэгтэй, 54% нь санал нэгтэй, 30% нь 50/50, 4% нь санал нэг биш гэж хариулсан.

Ажилчдын санал бодлыг сонсох




Энэ эмнэлэг ажилчдынхаа санал бодлыг сонсож мэдэхийн тулд хүчин чармайлт гаргадаг уу гэсэн асуултад 14% нь бүрэн санал нэгтэй, 32% нь санал нэгтэй, 40% нь 50/50, 12% нь санал нэг биш, 2% нь огт үгүй гэж хариулсан.

Удирдлагын эргэх холбоо




Та ажлынхаа үр дүнгийн талаар, мөн түүнийг сайжруулах тал дээр удирдлагын зүгээс үнэлгээ авч, буцах холбоотой ажилладаг байсан нь ажлаа улам сайн хийхэд минь нэмэр болсон уу гэсэн асуултад 20% нь бүрэн санал нэгтэй, 36% нь санал нэгтэй, 32% нь 50/50, 8% нь санал нэг биш, 4% нь огт үгүй гэж хариулсан.

Шууд удирдлага




Таны шууд удирдлага (тасгийн эрхлэгч, сувилахуйн арга зүйч) тань удирдлаган доор ажиллагчдынхаа бүхий л нөөц боломж, мэдлэг чадвар, бодол санааг бүрэн дайчлан эмнэлгийн үйл ажиллагааныхаа үр дүнг сайжруулахыг ямагт хичээдэг байсан уу гэсэн асуултад 30% нь бүрэн санал нэгтэй, 40% нь санал нэгтэй, 22% нь 50/50, 6% нь санал нэг биш, 2% нь огт үгүй гэж хариулсан.

Шууд удирдлагад итгэх итгэл



Таны шууд удирдлага /тасгийн эрхлэгч, арга зүйч/ тань итгэл хүлээлгэж болох хүн гэдэгт та хэр зэрэг итгэдэг вэ гэсэн асуултад 32% нь маш их итгэдэг, 38% нь итгэдэг, 20% нь 50/50, 4% нь итгэдэггүй, 6% нь огт итгэдэггүй гэж хариулсан.


Ажлын дадлага туршлага нэмэгдэх боломж



Тус эмнэлэгт ажилласнаараа өөрийнхөө ажлын дадлага туршлагыг нэмэгдүүлэх боломжтой байсан эсэх талаар асуултад

46% нь бүрэн санал нэгтэй, 36% нь санал нэгтэй, 14% нь 50/50, 4% нь санал нэг биш гэж хариулсан.

Шууд удирдлагаас зөвлөмж, удирдамж авах боломж





Та өөрийн шууд удирдлагаасаа /тасгийн эрхлэгч, арга зүйч/ ажил мэргэжлийн сайн удирдамж, зөвлөмжийг авдаг байсан уу гэсэн асуултад 40% нь бүрэн санал нэгтэй, 46% нь санал нэгтэй, 8% нь 50/50, 2% нь санал нэг биш, 4% нь огт үгүй гэж хариулжээ.

Албан тушаал өсөх талаарх итгэл



Та карьерийн (албан тушаал) өсөлтийнхөө талаар өөртөө итгэлтэй байсан бэ гэсэн асуултад 18% нь маш итгэлтэй, 52% нь итгэлтэй, 24% нь дунд зэрэг, 4% нь бага зэрэг, 2% нь маш бага гэж хариулсан.

Нийгмийн халамж, хөнгөлөлт

							 Та өөрт олгогдож байсан нийгмийн халамж, хөнгөлөлтийг хэр үнэлж байна вэ гэсэн асуултад 8% нь маш сайн, 54% нь сайн, 24% нь дунд зэрэг, 6% нь бага зэрэг, 8% нь маш бага гэж үнэлжээ. Цалин ажлын бүтээмжийн уялдаа  Таны цалин таны ажлын бүтээмжид тохирч байсан гэж бодож байна уу гэсэн асуултад 2% нь бүрэн санал нэгтэй, 16% нь санал нэгтэй, 46% нь 50/50, 24% нь санал нэг биш, 12% нь огт үгүй гэж хариулжээ.
4.4	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын чиглэлээр нэвтрүүлсэн шилдэг санаачилга, үйл ажиллагааг шалгаруулж, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын чиглэлийн шилдэг санаачлага, үйл ажиллагаа	Нийгмийн хамгааллын чиглэлээр ЭМБ-ууд түгээн дэлгэрүүлсэн шилдэг туршлага, үйл ажиллагааны тоо				• Үндэсний үйлдвэрлэгч Анартехс ХХК болон эмнэлэг, эмнэлгийн Үйлвэрчний эвлэлийн хороо хамтран ажилтнуудын хүүхдүүдэд зориулж сурагчийн дүрэмт хувцсыг 20-50% хямдралтай үнээр, 1 сарын хугацаатай хүүгүй зээлээр худалдан авах үзэсгэлэн худалдааг 2022 оны 08 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд эмнэлэг дээрээ зохион байгуулсан. • Улсын Хоёрдугаар төв эмнэлгийн дэргэд 100 хүүхдийн ортой цэцэрлэг шинээр байгуулагдаж Баянзүрх дүүргийн 50 дугаар цэцэрлэгийн салбар бүлэг болсноор 24 дэх байгууллагын цэцэрлэг болон үйл ажиллагаагаа явуулж байна. Одоо

								цэцэрлэг нийт 100 гаруй хүүхдийг хүлээн авч, дөрвөн бүлэг, 22 багш, ажилтантай үйл ажиллагаа явуулж байна. • Байгууллагын дэргэдэх хүүхдийн өндөр өнжүүлэх төв ажиллуухаар ажилтнуудаас судалгаа авсан бөгөөд 54 ажилтны 6-15 насны нийт 74 хүүхэд хамрагдах хүсэлт гаргасан байна. • Мобиком корпорациас байгууллагын мобиком хэрэглэгч бүх ажилтнуудад 2022 оны турш сар бүр 10 гб дата эрхээр урамшууллаа. • Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн өдөр “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал” сэдэвт өдөрлөг, сургалтын хөтөлбөрийн хүрээнд 2022 оны 6-р сарын 20-ны өдөр УХТЭ-ийн ҮОЭТ-ийн 1 давхарт амжилттай зохион байгууллаа. Тус өдөрлөгийн зорилго нь УХТЭ-ийн оношилгоо, эмчилгээний тасгуудын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 6 зорилтыг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн ажилтны үйлчлүүлэгчтэй харилцах хандлагыг сайжруулах, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах зэрэгт оршино. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 6 зорилтод тулгуурлан зорилт бүрээр ширээ ажиллуулж байна. Үүнд: • Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах • Аман заавар өгөх • Өндөр эрсдэлт эмийн аюулгүй байдал • Мэс заслын аюулгүй байдал, • Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын эрсдэлийг бууруулна • Унах бэртэх эрсдэлийг бууруулах ширээг тус тус зохион байгуулан ажиллаж байна. Өдөрлөгийн хүрээнд УХТЭ-ийн бүх тасаг нэгжүүд нийт 20 ширээг засан оролцож байна. Үүнд: Бүх тасаг нэгжүүд өөрсдийн аюулгүй байдлын зорилтуудыг хэрхэн хэрэгжүүлдэг талаар болон тасаг нэгжүүдийн эмчилгээ, үйлчилгээ, үйл ажиллагааны талаарх ширээнүүдийг өөрсдийн чиглэл, онцлогын дагуу тохижуулан, танин мэдэхүйн хэвлэмэл хуудас, тараах материал, тусламж, үйлчилгээ үзүүлэх багаж хэрэгслийг байрлуулж эмнэлгээр
--	--	--	--	--	--	--	--	--

								үйлчлүүлэгч нарт танилцууллаа. Нийт өдөрлөгийн үеээр 150 гаруу иргэд оролцож аюулгүй байдлын тухай мэдээлэлтэй боллоо. - Ахмад настны нийгмийн хамгааллын тэтгэмжийн тухай хуулийн 8.4 дэх заалт, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 09 дүгээр зүйлийн 9.4.3 дахь заалтын дагуу Ахмадын өдрөөр байгууллагын 265 ахмадуудад хүндэтгэл үзүүлж нийт 8,920,000 төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгосон. (Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны А/96 дугаар тушаал - Жил бүрийн 9 дүгээр сарын 16-ны өдөр Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн өдөр болдог билээ энэ жил “Эмийн хэрэглээний аюулгүй байдал - Эмийг зөв хэрэглэе” уриа дор явагдаж байгаа бөгөөд УХТЭ дээр эмийн зөв зохистой хэрэглээний өдөрлөг зохион байгуулагдлаа. Уг өдөрлөгөөр үйлчлүүлэгчид эмийг аюулгүй байдал болон эмийг зөв хэрэглэх 5 алхам болох 1. Эмийг хэрэглэхийн өмнө юу анхаарах вэ? 2. Эм хэрэглэх үед 3. Нэмэлт эм хэрэглэх үед 4. Хэрэглэж байгаа Эмээ хянах үед 5. Эмийн эмчилгээг зогсоох үед гэсэн агуулга бүхий гарын авлага тараан иргэдэд мэдээлэл өглөө. Зүрхээ хамгаалах дэлхийн өдрийн хүрээнд “Зүрхний цус хомсрох өвчин” сэдэвт өдөрлөг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Зүрх судас судлалын тасгаас 2022 оны 9 сарын 29 өдөр "Зүрхний цус хомсрох өвчин" сэдэвт өдөрлөг, сургалтын арга хэмжээг зохион байгуулан ажиллаа. Өдөрлөгөөр иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох үүднээс Зүрхний цус хомсрох өвчний тухай зөвлөгөө зөвлөмжийг мэргэжлийн эмч нар өглөө. Үүнд: - Зүрхний цус хомсрох өвчин гэж юу вэ? - Зүрхний цус хомсрох өвчин ямар шинж тэмдгээр илрэх вэ? - Зүрхний цус хомсрох өвчнийг хэрхэн оношлох вэ? - Зүрхний цус хомсрох өвчин илрэх үед өөртөө хэрхэн тусалж чадах вэ?
--	--	--	--	--	--	--	--	---

								• Зүрхний цус хомсрох өвчнийг хэрхэн эмчлэх вэ? Энэхүү өвчний тухай иргэдэд дэлгэрэнгүй зөвлөгөө мэдээлэл өгсөн сургалт боллоо. Өдөрлөгт нийт 70 гаруй иргэд хамрагдаж оролцсон нийт иргэдэд зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх гарын авлага тараан өгсөн. “ТАРХИНЫ ХАРВАЛТТАЙ ТЭМЦЭХ ДЭЛХИЙН ӨДӨР” ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН Улсын Хоёрдугаар Төв эмнэлэг “Тархины харвалттай тэмцэх дэлхийн өдөр” тохиолдуулан өнөөдөр Мэдрэл судлалын тасгийн харьяа Харвалтын нэгжийн нээлтийг хийж, “Харвалтаас урьдчилан сэргийлэх боломж танд бий” сэдэвт нээлттэй хаалганы өдөрлөгийг 2022 оны 10 сарын 25 өдөр зохион байгуулсан. Өдөрлөгийн үеэр 30 үйлчлүүлэгчдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийж, зөвлөгөө болон харвалтын дараах асаргаа сувилгаа, хяналтын талаар мэдээлэл өглөө. Эмнэлгийн Ерөнхий захирал Б.Эрдэнэбулган “УХТЭ нь сүүлийн хоёр жилийн хугацаанд Оношилгоо, эмчилгээний үндэсний төв ашиглалтад оруулж, үндэсний хэмжээний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж байна. ЭМЯ-аас барьж буй төвлөрлийг сааруулах, иргэдэд хүртээмжтэй чанартай тусламж, үйлчилгээг үзүүлэх бодлогын хүрээнд өвчлөл ихтэй байгаа хэсгүүдэд анхаарч ажиллаж байна. Үүний нэг нь Мэдрэлийн тусламж, үйлчилгээ юм. Мөн манай эмнэлгийн Харвалтын нэгж энэ оны 5 дугаар сараас үйл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд Зүүн бүсийн таван аймаг, алслагдсан гурван дүүргийн нийт 100 гаруй иргэнд харвалтын яаралтай тусламжийг үзүүлсэн байна.
--	--	--	--	--	--	--	--	--

4.6	Эрүүл мэндийн ажилтны нэр хүнд, мэргэжлийн онцлог, үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах	Эрүүл мэндийн ажилтны нэр хүнд, мэргэжлийн онцлог, үйл ажиллагааг сурталчилсан мэдээ, нэвтрүүлэг	Албан ёсны хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан эрүүл мэндийн ажилтны нэр хүнд, мэргэжлийн онцлог, үйл ажиллагааг сурталчилсан мэдээ, нэвтрүүлгийн тоо					Нийгмийн эрүүл мэндийн алба нь цахим сүлжээгээр дамжуулан иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх мөн эмнэлгийн үйл ажиллагааг танилцуулах зорилгоор нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөгөөг хүргэж эхэлсэн. Эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэлийн цуврал контентийг 7 төрлийн сэдэвийн хүрээнд явуулсан. 1. Уушги судлалын тасгийн эмч Э.Цээпил 2022 оны 03 сарын 23 нд Корона вируст халдварын дараах уушгины эмгэгийн асуудал сэдвээр иргэдэд эрүүл мэндийн зөвлөмж болон мэдээлэл өгсөн. Лайв контентын хандалт нь 650 хүний үзэлттэй, 29 хүн бусдад цааш түгээсэн /Share/ үзүүлэлттэй байна. 2. Дүрс оношилгооны тасгийн их эмч Ц.Отгонтуяа 2022 оны 03 сарын 30 нд Рентген шинжилгээ ба Ковид гэсэн сэдвээр иргэдэд эрүүл мэндийн зөвлөмж болон мэдээлэл өгсөн. Лайв контентын хандалт нь 1200 хүний үзэлттэй, 87 хүн бусдад цааш түгээсэн/Share/ төлөвтэй байна. 3. Ерөнхий мэс заслын тасгийн их эмч М.Түвшинбаяр 2022 оны 04 сарын 6 нд Хөхний мэс засал эмчилгээ сэдвээр иргэдэд эрүүл мэндийн зөвлөмж болон мэдээлэл өгсөн. Лайв контентын хандалт нь 1786 хүний үзэлттэй, 69 хүн бусдад цааш түгээсэн байна. 4. Ерөнхий мэс заслын тасгийн их эмч Б.Ган-Эрдэнэ 2022 оны 04 сарын 15 нд “Нойр бурчирхайн хавдар” сэдвээр иргэдэд эрүүл мэндийн боловсрол, зөвлөгөө мэдээлэл хүргэсэн. Лайв контентын хандалт нь 3218 хүний үзэлттэй, 200 хүн бусдад цааш түгээсэн байна. 5. Ангиографикийн тасгийн их эмч М.Батмөнх 2022 оны 04 сарын 20 нд “Хөлийн судасны эмгэгүүдийн оношилгоо” сэдвээр иргэдэд эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөөг өгсөн. Энэхүү лайв контентын хандалт нь 489 хүний үзэлттэй, 52 хүн бусдад цааш түгээсэн байна. 6. Сэргээн засах эмчилгээний тасгийн их эмч 2022 оны 04 сарын 27 өдөр Э.Цэнд-Аюуш “Нурууны өвдөлт түүний сэргээн засах эмчилгээ” сэдвээр иргэдэд эрүүл мэндийн боловсрол, зөвлөгөө мэдээлэл хүргэсэн. Лайв контентын хандалт нь 209 хүний үзэлттэй, 43 хүн бусдад цааш түгээсэн байна. 7. Амбулаторийн тасгийн эрхлэгч Д.Солонго 2022 оны 05 сарын 18 өдөр “Урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээний ач холбогдол” сэдвээр иргэдэд мэдээлэл өглөө. Лайв контентын
-----	---	--	--	--	--	--	--	--

4.7	Сул ажлын байрны мэдээний нэгдсэн цахим хуудсыг нийт эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудастай холбох, үйл ажиллагааг тогтмолжуулах	Сул ажлын байрны мэдээний нэгдсэн цахим хуудас	Сул ажлын байрны мэдээний нэгдсэн цахим хуудасны хандалтын тоо					• https://info.shilendans.gov.mn/login “Шилэн данс”-д байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг сар бүр тайлагнасан. • Эмнэлгийн ЦАХИМ хуудасны http://ssch.gov.mn/ “АЖЛЫН БАЙРНЫ ЗАР” буланд 132 удаа нийт 48 ажлын байрны зар, эмнэлгийн Facebook хуудас дээр 81 удаа 48 ажлын байрны зарыг байршуулсан • Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд 3 ажлын байрны захиалга өгсөн. • 2022 оны 05 дугаар сарын 09-нд 10-12 цагт Этүгэн их сургуулийн сувилахуйн сургуулийн 67 төгсөгчийг “Сувилагч мэргэжлийн бахархал” сэдэвт эмнэлгийн танилцуулга, тойрон аяллыг зохион байгуулсан. • Энэрэл дээд сургуулийн “Ажил олгогчийн нээлттэй хаалганы өдөрлөг”-т байгууллагын танилцуулга, ажлын байрны зарыг видео шторкыг хүргүүлэн оролцсон. • Монгол Улсын хэрэгжүүлэгч агентлаг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын мэргэжилтэн Н.Дорждэрэмтэй хамтран ажиллаж үйлчлэгч, цахим бүртгэл лавлагааны ажилтны ажлын байранд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд авах санал, хүсэлтийг хүргүүлсэн. • Эрүүл мэндийн хөгжлийн төвийн “Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан” програмд ажлын байрны зар тогтмол оруулж байна.
-----	---	--	--	--	--	--	--	--